**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/02/НА- СТА-ТШЗ**

---

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
Аудитын гол асуудал ........ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 14
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 18
4.1 Ерөнхий зүйл ........ 18
4.2 Материаллаг байдал ........ 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 19
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 19
5.1 Төлбөрийн акт ........ 20
5.2 Албан шаардлага ........ 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМДХ | Эрүүл мэндийн даатгалын хэлтэс |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/47

танай____________-ны № _____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Ж.ГАНЗУЛ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 71602 (Эмнэлгийн тусламж үйлчилгээ) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМДС-аас баталсан 16,320,454.5 мянган төгрөгийн санхүүжилтээс 236,335.9 мянган төгрөгийг дутуу буюу 16,084,118.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан, үндсэн үйл ажиллагааны орлогоор 405,246.2 мянган төгрөг оруулахаас 367,511.2 мянган төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/201 тушаалаар бүтэц орон тоонд өөрчлөлт орж 62 орон тоо нэмэгдсэн боловч цалингийн сангийн сан нэмэгдээгүй байна

**Аудитын гол асуудал**

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт Шинэ амбулаторийн барилга, Эмгэг судлалын барилга шинээр 2024 оны 12 дугаар сард улсын комисс хүлээн авч ашиглахад боломжтой байхад одоог болтол нүүж ороогүй, 12 дугаар сараас эхлэн сар бүр халаалтын зардалд 28,000.0 мянган төгрөгийг төсвөөс төлж байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

5020272

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ТУЗ-өөс 84.6 хувиар дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн яамнаас 79,110.0 мянган төгрөгийн 90 ширхэг таблет хуваарилж, сувилагч нарын ажлыг хөнгөвчлөн e-health программыг суулгаж ашиглахаар олгосон ч тус программыг суулгаагүй байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

[illegible] .

[illegible] 405 , 246 . 2 [illegible] 367 , 511 . 2 [illegible]

[illegible] 16 , 084 , 118 . 6 [illegible] , [illegible]

[illegible] 16 , 320 , 454 . 5 [illegible] 236 , 335 . 9 [illegible]

[illegible] , 71602 ( [illegible] ) [illegible]

[illegible]

[illegible] ..

[illegible] .. [illegible]

[illegible] . [illegible] ..

[illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31-[illegible]

[illegible] ..

[illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31 [illegible]

[illegible] 8 [illegible] 8.9.1 [illegible]

[illegible] 6 [illegible] 6.3.1 · 8 [illegible] 8.1 · [illegible]

[illegible]

[illegible] ___ [illegible] ___

[illegible] 01/28 [illegible] 2024-01-21

[illegible]

[illegible] : procurement. bayankhongor@audit.gov.mn
[illegible] · 64101 · [illegible]: (976) 70442584
[illegible] 1 [illegible]
310 [illegible] 3

0062502018[8]

ᠬᠣᠯᠪᠣ᠂ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ᠂ ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠪᠡᠷ ᠬᠠᠮᠲᠤ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠵᠦᠢᠯ ᠦᠳ ᠢ ᠪᠦᠷᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ::

ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠬᠣᠪᠢ ᠳᠦ ᠳᠡᠭᠡᠭᠰᠢ ᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦ ᠪᠠᠨ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠭᠴᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ

ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠰᠢᠯᠭᠠᠨ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠬᠤ

ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ᠂ ᠰᠢᠯᠭᠠᠨ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠯᠲᠠ

ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠰᠠᠢᠨ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ::

ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠦᠵᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢ ᠪᠦᠷᠢᠨ ᠬᠦᠷᠴᠦ ᠲᠡᠭᠦᠰᠦᠭᠰᠡᠨ ᠦ ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦᠨ :: ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦᠨ ᠦ ᠲᠡᠭᠦᠰᠬᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ

ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠵᠢᠷᠤᠮ ᠬᠦᠷᠳᠦᠴᠡ ᠪᠠ ᠠᠵᠢᠯ᠂ ᠴᠢᠨᠠᠷ᠂

ᠠᠰᠢᠭ ᠲᠤᠰᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠰᠠᠢᠨ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ::

ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠠᠰᠢᠭ ᠲᠤᠰ᠂ ᠡᠳ᠋ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠦᠮᠦᠰ ᠦᠨ ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠠᠰᠢᠭ ᠲᠤᠰ ᠤᠨ ᠡᠳ᠋ ᠡᠳ᠋ ᠦᠨ ᠦᠷ᠎ᠡ ᠳᠦᠩ ᠦᠨ

ᠣᠷᠴᠢᠨ ᠤ ᠲᠤᠭᠤᠷᠢᠯ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠤᠪᠢ᠂ ᠣᠷᠴᠢᠨ ᠤ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠣᠷᠴᠢᠨ ᠤ ᠠᠰᠢᠭ ᠲᠤᠰ᠂ ᠬᠦᠮᠦᠰ ᠦᠨ

ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠤᠪᠢ ᠳᠦ ᠣᠷᠴᠢᠨ ᠤ ᠲᠤᠭᠤᠷᠢᠯ ᠳᠤ ᠰᠠᠢᠨ ᠨᠥᠯᠦᠭᠡ ᠦᠵᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠂ ᠰᠠᠢᠰᠢᠶᠠᠯᠲᠠ

ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ .

ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦᠨ ᠦ ᠬᠦᠷᠳᠡᠯ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠂ ᠬᠦᠷᠳᠡᠯ ᠳᠦ ᠬᠦᠷᠭᠡᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠳᠠᠭᠠᠤ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠡᠨ ᠦ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ

ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠰᠠᠨᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠦᠨ 2024 ᠣᠨ ᠤ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠲᠥᠰᠥᠪ ᠪᠣᠯᠤᠨ ᠂

ᠬᠦᠷᠭᠡᠭᠰᠡᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ .

ᠬᠡᠷ ᠦᠨ ᠡᠮᠴᠢ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ e health ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮ ᠦᠨ ᠰᠠᠯᠪᠤᠷ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠤᠷᠤᠯᠲᠠ ᠮᠡᠳᠡᠭᠡ ᠶᠢᠨ ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮ ᠦᠨ

ᠬᠣᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠳᠦ 79 , 110 . 0 ᠮᠢᠩᠭᠠ ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ 90 ᠬᠤᠪᠢ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠡᠶᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ ᠂ ᠪᠡᠶᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠯᠲᠡ

ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢᠶᠠᠨ ᠬᠤᠪᠢ 84 . 6 ᠬᠤᠪᠢ ᠳᠤ ᠬᠦᠷᠴᠡᠢ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ .

ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠰᠠᠨᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠦᠨ 2024 ᠣᠨ ᠤ ᠪᠡᠶᠡᠯᠡᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦᠨ ᠦ ᠲᠡᠭᠦᠰᠬᠡᠯ ᠦ

**ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠩ**

ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ ᠪᠣᠯᠤᠨ ::

ᠡᠮᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠬᠡᠷ ᠬᠦ ᠦᠨᠡᠯᠡᠯ ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠬᠦᠷᠦ ᠬᠣ ᠵᠢ

ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠠ ᠵᠢ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠳᠦ ᠵᠢ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ᠂ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠦ

ᠬᠦᠷᠡᠯᠡᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯ ᠪᠣᠯ ᠬᠦ ᠬᠤᠪᠢ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠠ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ :: ᠦᠨᠡᠯᠡ

ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡ ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠵᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠳᠦ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠳᠡᠯ ᠦᠨ

ᠬᠦᠷᠦᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠳᠦ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠰᠡᠨ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ .

ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠂ 12 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦ ᠬᠦᠷᠲᠡᠯ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠦᠷᠭᠡᠭᠰᠡᠨ ᠦ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠳᠦ 28 , 000 . 0 ᠮᠢᠩᠭᠠ

2024 ᠣᠨ ᠤ 12 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦ ᠬᠦᠷᠲᠡᠯ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠦᠷᠭᠡᠭᠰᠡᠨ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠨ ᠪᠣᠯ ᠪᠠᠢᠨ ᠳᠦ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠤᠨ

ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠰᠠᠨᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠵᠢᠯ ᠳᠦ ᠬᠦᠷᠭᠡ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠂ ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠷᠳᠡᠯ ᠦᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠦᠷᠦ ᠪᠠᠢ

**ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠦᠨᠡᠯᠡ ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠠ**

ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢ 62 ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠷ ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠦᠷ ᠶᠢᠨ ᠬᠦᠷ ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠬᠦ ᠪᠣᠯᠤᠨ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ

ᠬᠣᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠰᠠᠨᠬᠦᠦ ᠶᠢᠨ 2024 ᠣᠨ ᠤ ᠰᠠᠷ᠎ᠠ / 201 ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠤᠪᠢ ᠠᠵᠢᠯ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ

ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠬᠥᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠤ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠩᠭᠤᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠦᠦᠷᠭᠡ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠭᠦᠯᠬᠦ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠳᠡᠮᠵᠢᠨ᠎ᠡ ::

ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠩᠭᠤᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠥᠲᠦᠯᠪᠦᠷᠢ ᠶᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠩᠭᠤᠢ ᠶᠢᠨ ᠴᠢᠨᠠᠷ ᠢ ᠳᠡᠭᠡᠭᠰᠢᠯᠡᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠩᠭᠤᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢ ᠰᠠᠢᠵᠢᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ::

ᠬᠦᠨᠳᠦᠳᠬᠡᠭᠰᠡᠨ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢᠢᠯᠡᠭᠴᠢ ᠴ᠂ ᠡᠯᠪᠡᠭᠳᠣᠷᠵᠢ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,010,758,871.02** | **4,094,000,032.59** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4,901,305.12 | 417,667,110.79 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 4,901,305.12 | 417,667,110.79 |
| **3121** | **Төгрөг** | 4,901,305.12 | 417,667,110.79 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,901,305.12 | 417,667,110.79 |
| **33** | **АВЛАГА** | 1,484,128,004.42 | 1,875,387,408.22 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,478,091,553.00 | 1,874,272,443.50 |
| **335** | **Бусад авлага** | 6,036,451.42 | 1,114,964.72 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 6,036,451.42 | 1,114,964.72 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 949,864,664.48 | 1,229,080,616.58 |
| **351** | **Түүхий эд материал** | 697,860,662.90 | 947,813,087.79 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 167,440,780.89 | 168,602,095.89 |
| 35130 | Эм боох материал | 530,419,882.01 | 779,210,991.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 252,004,001.58 | 281,267,528.79 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,836,400.00 | 2,385,740.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,673,128.20 | 4,289,315.40 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,065,420.25 | 4,065,420.25 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.01 | 00.02 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,668,000.00 | 1,274,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 907,300.00 | 3,389,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 232,853,753.12 | 265,863,553.12 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 571,864,897.00 | 571,864,897.00 |
| 36100 | Барааны нөөц | 571,864,897.00 | 571,864,897.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,411,591,945.24** | **15,373,038,338.84** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 16,411,591,945.24 | 15,373,038,338.84 |
| **392** | **Биет хөрөнгө** | 14,947,760,884.28 | 13,894,341,558.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,624,504,963.00 | 9,624,504,963.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -814,319,443.58 | -980,580,745.62 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 821,187,962.00 | 1,271,256,553.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -331,555,110.04 | -442,804,130.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 12,301,657,979.50 | 12,725,740,621.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,992,621,376.89 | -8,571,090,000.31 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 678,052,136.82 | 696,047,146.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -339,146,226.53 | -428,732,850.08 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,463,831,060.96 | 1,478,696,780.41 |
| 39301 | Програм хангамж | 54,707,022.00 | 81,457,022.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -38,700,961.04 | -50,585,241.59 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,447,825,000.00 | 1,447,825,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **19,422,350,816.26** | **19,467,038,371.43** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,757,062,351.22** | **1,596,673,106.80** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,757,062,351.22 | 1,596,673,106.80 |
| **413** | **Өглөг** | 1,757,062,351.22 | 1,596,673,106.80 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 591,375,896.41 | 889,003,821.08 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,037,652,154.81 | 690,405,585.72 |
| **4136** | **Бусад өглөг** | 128,034,300.00 | 17,263,700.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 26,980,400.00 | 7,763,700.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 101,053,900.00 | 9,500,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **17,665,288,465.04** | **17,870,365,264.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 17,665,288,465.04 | 17,870,365,264.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,725,816,344.70 | 6,725,816,344.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 6,725,816,344.70 | 6,725,816,344.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8,080,112,098.32 | 8,285,188,897.91 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 8,080,112,098.32 | 8,080,112,098.32 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 205,076,799.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,859,360,022.02 | 2,859,360,022.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **19,422,350,816.26** | **19,467,038,371.43** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **14,777,120,627.38** | **19,375,749,825.87** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,358,241,328.38** | **1,363,500,340.87** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,358,241,328.38 | 1,363,500,340.87 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,358,241,328.38 | 1,363,500,340.87 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 344,157,100.00 | 366,556,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 814,084,228.38 | 996,944,040.87 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **13,418,879,299.00** | **18,012,249,485.00** |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 00.00 | 1,512,000,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 114,469,329.00 | 19,950,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 114,469,329.00 | 1,531,950,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 13,304,409,970.00 | 16,480,299,485.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,304,409,970.00 | 16,480,299,485.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **16,554,709,405.59** | **19,155,889,401.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,554,709,405.59** | **19,155,889,401.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 16,537,989,127.59 | 19,126,415,019.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 8,310,232,696.00 | 10,617,016,090.00 |
| 210101 | Үндсэн цалин | 4,560,378,385.00 | 5,582,278,011.00 |
| 210102 | Нэмэгдэл | 3,167,146,195.00 | 3,976,072,944.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 214,818,000.00 | 259,793,000.00 |
| 210104 | Урамшуулал | 367,890,116.00 | 798,872,135.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,053,046,658.10 | 1,374,461,895.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 725,404,832.78 | 937,212,537.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 85,463,799.45 | 108,577,159.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 66,760,639.10 | 77,475,612.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,943,917.21 | 50,070,107.74 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 159,473,469.56 | 201,126,478.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,174,435,663.00 | 1,290,890,720.17 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 136,527,727.00 | 144,423,148.17 |
| 210302 | Түлш, халаалт | 798,540,160.00 | 906,830,144.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 239,367,776.00 | 239,637,428.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 272,001,316.14 | 296,439,930.95 |
| 210401 | Бичиг хэрэг | 24,882,270.00 | 14,535,427.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 109,241,605.60 | 127,849,880.45 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,139,837.54 | 11,817,072.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 76,941,950.00 | 96,728,850.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 48,795,653.00 | 45,508,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,435,874,517.93 | 3,106,606,485.56 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,046,145,307.93 | 2,694,577,345.56 |
| 210502 | Хоол, хүнс | 389,729,210.00 | 373,611,640.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 38,417,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 46,644,755.00 | 121,529,520.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 784,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 46,644,755.00 | 120,745,520.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 24,465,000.00 | 31,468,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,465,000.00 | 31,468,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 234,500,815.00 | 314,597,951.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 213,478,652.00 | 266,644,843.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,199,525.00 | 3,200,000.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,365,788.00 | 889,948.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 264,000.00 | 286,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,791,200.00 | 5,791,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 10,401,650.00 | 35,285,960.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,986,787,706.42 | 1,973,404,225.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 795,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,986,787,706.42 | 1,972,609,225.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,720,278.00 | 29,474,382.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,720,278.00 | 29,474,382.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,720,278.00 | 29,474,382.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-1,777,588,778.21** | **219,860,424.59** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,171,959,888.58 | 14,540,625.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,162,719,238.58 | 14,540,625.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 9,240,650.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,171,959,888.58 | -14,540,625.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-2,949,548,666.79** | **205,319,799.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **12,491,164,730.25** | **17,983,822,762.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **547,185,984.25** | **367,754,168.30** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 547,185,984.25 | 367,754,168.30 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 547,185,984.25 | 367,754,168.30 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 347,185,984.25 | 367,754,168.30 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **11,943,978,746.00** | **17,616,068,594.50** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 114,469,329.00 | 1,531,950,000.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 00.00 | 1,512,000,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 114,469,329.00 | 19,950,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 11,829,509,417.00 | 16,084,118,594.50 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 11,829,509,417.00 | 16,084,118,594.50 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **12,526,359,092.80** | **17,505,922,347.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,526,359,092.80** | **17,505,922,347.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,508,747,814.80** | **17,477,321,965.13** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,658,847,730.69 | 10,095,727,421.89 |
| 210101 | Үндсэн цалин | 3,447,370,325.69 | 4,811,748,035.89 |
| 210102 | Нэмэгдэл | 3,624,702,146.00 | 4,021,062,014.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 221,628,589.00 | 327,021,168.00 |
| 210104 | Урамшуулал | 365,146,670.00 | 935,896,204.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,109,926,300.00 | 1,598,179,945.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 796,849,200.00 | 1,237,225,545.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 78,269,300.00 | 90,238,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 62,615,300.00 | 72,190,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,653,900.00 | 18,047,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 156,538,600.00 | 180,477,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 865,139,819.00 | 1,512,000,036.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 136,527,727.00 | 144,423,148.17 |
| 210302 | Түлш, халаалт | 529,087,600.00 | 1,088,096,175.83 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 199,524,492.00 | 279,480,712.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 258,078,687.54 | 299,580,754.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,815,200.00 | 17,283,770.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 111,365,300.00 | 118,855,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,139,837.54 | 11,817,072.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 62,564,450.00 | 80,895,512.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 60,193,900.00 | 70,729,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,195,994,717.57 | 3,403,172,429.34 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,822,261,897.57 | 2,971,320,189.34 |
| 210502 | Хоол, хүнс | 373,412,820.00 | 391,793,740.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 320,000.00 | 40,058,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 251,045,767.00 | 116,988,486.40 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,553,000.00 | 7,176,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 2,044,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 234,492,767.00 | 107,768,486.40 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 24,497,000.00 | 31,660,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,497,000.00 | 31,660,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 145,217,793.00 | 419,217,691.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 114,097,280.00 | 371,503,543.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,199,525.00 | 3,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,365,788.00 | 889,948.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 264,000.00 | 286,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,791,200.00 | 5,791,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 20,500,000.00 | 35,047,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 795,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 795,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,611,278.00** | **28,600,382.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,611,278.00 | 28,600,382.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,611,278.00 | 28,600,382.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-35,194,362.55** | **477,900,415.67** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **312,197,368.00** | **65,134,610.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **312,197,368.00** | **65,134,610.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 312,197,368.00 | 65,134,610.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 312,197,368.00 | 65,134,610.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-312,197,368.00** | **-65,134,610.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -347,391,730.55 | 412,765,805.67 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 352,293,035.67 | 4,901,305.12 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 4,901,305.12 | 417,667,110.79 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 5,277,991,344.70 | 2,935,236,347.00 | -119,985,806.28 | 8,093,241,885.42 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,277,991,344.70** | **2,935,236,347.00** | **-119,985,806.28** | 8,093,241,885.42 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -110,448,584.16 | -110,448,584.16 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,080,112,098.32** | 17,665,288,465.04 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,080,112,098.32** | 17,665,288,465.04 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,080,112,098.32** | 17,665,288,465.04 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 205,319,799.59 | 205,319,799.59 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,285,431,897.91** | 17,870,608,264.63 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 18,257,650,700.00 | 17,570,813,957.13 | 686,836,742.87 | 96.24 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 18,257,650,700.00 | 17,570,813,957.13 | 686,836,742.87 | 96.24 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 18,228,504,500.00 | 17,542,213,575.13 | 686,290,924.87 | 96.24 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 10,194,078,800.00 | 10,095,727,421.89 | 98,351,378.11 | 99.04 |
| 210101 | Үндсэн цалин | 4,844,307,000.00 | 4,811,748,035.89 | 32,558,964.11 | 99.33 |
| 210102 | Нэмэгдэл | 4,088,239,400.00 | 4,021,062,014.00 | 67,177,386.00 | 98.36 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 214,818,000.00 | 327,021,168.00 | (112,203,168.00) | 152.23 |
| 210104 | Урамшуулал | 1,046,714,400.00 | 935,896,204.00 | 110,818,196.00 | 89.41 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,598,180,000.00 | 1,598,179,945.40 | 54.60 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,054,452,300.00 | 1,237,225,545.40 | (182,773,245.40) | 117.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 273,011,900.00 | 90,238,600.00 | 182,773,300.00 | 33.05 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 72,190,900.00 | 72,190,900.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,047,700.00 | 18,047,700.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 180,477,200.00 | 180,477,200.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,002,375,700.00 | 1,512,000,036.00 | 490,375,664.00 | 75.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 130,427,700.00 | 144,423,148.17 | (13,995,448.17) | 110.73 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 1,533,266,200.00 | 1,088,096,175.83 | 445,170,024.17 | 70.97 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 338,681,800.00 | 279,480,712.00 | 59,201,088.00 | 82.52 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 316,618,900.00 | 316,040,654.60 | 578,245.40 | 99.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,600,000.00 | 17,283,770.00 | 316,230.00 | 98.20 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 112,530,000.00 | 118,855,400.00 | (6,325,400.00) | 105.62 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,123,000.00 | 11,817,072.60 | (694,072.60) | 106.24 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,277,500.00 | 80,895,512.00 | (10,618,012.00) | 115.11 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 105,088,400.00 | 87,188,900.00 | 17,899,500.00 | 82.97 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,403,172,600.00 | 3,402,929,429.34 | 243,170.66 | 99.99 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,872,531,000.00 | 2,971,077,189.34 | (98,546,189.34) | 103.43 |
| 210502 | Хоол, хүнс | 391,383,100.00 | 391,793,740.00 | (410,640.00) | 100.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 139,258,500.00 | 40,058,500.00 | 99,200,000.00 | 28.77 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 166,609,200.00 | 165,663,196.40 | 946,003.60 | 99.43 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,950,000.00 | 50,365,400.00 | 584,600.00 | 98.85 |
| 210602 | Тавилга | 5,500,000.00 | 5,485,310.00 | 14,690.00 | 99.73 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,300,000.00 | 2,044,000.00 | 256,000.00 | 88.87 |
| 210604 | Урсгал засвар | 107,859,200.00 | 107,768,486.40 | 90,713.60 | 99.92 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 31,679,400.00 | 31,660,200.00 | 19,200.00 | 99.94 |
| 210702 | Дотоод албан томилолт | 31,679,400.00 | 31,660,200.00 | 19,200.00 | 99.94 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 514,789,900.00 | 419,217,691.50 | 95,572,208.50 | 81.43 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 465,128,000.00 | 371,503,543.50 | 93,624,456.50 | 79.87 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,200,000.00 | 3,200,000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,500,000.00 | 889,948.00 | 1,610,052.00 | 35.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 623,700.00 | 286,000.00 | 337,700.00 | 45.86 |
| 210807 | Газрын төлбөр | 5,791,200.00 | 5,791,200.00 | - | 100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 35,047,000.00 | 35,047,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1000000.00 | 795000.00 | 205,000.00 | 79.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 795,000.00 | 205,000.00 | 79.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29146200.00 | 28600382.00 | 545,818.00 | 98.13 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,146,200.00 | 28,600,382.00 | 545,818.00 | 98.13 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,146,200.00 | 28,600,382.00 | 545,818.00 | 98.13 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 18,257,650,700.00 | 17,983,579,762.80 | 274,070,937.20 | 98.50 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,512,000,000.00 | 1,512,000,000.00 | - | 100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 19,950,000.00 | 19,950,000.00 | - | 100.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 16,320,454,500.00 | 16,084,118,594.50 | 236,335,905.50 | 98.55 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,320,454,500.00 | 16,084,118,594.50 | 236,335,905.50 | 98.55 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 405,246,200.00 | 367,511,168.30 | 37,735,031.70 | 90.69 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 405,246,200.00 | 367,511,168.30 | 37,735,031.70 | 90.69 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 4,901,305.12 | (4,901,305.12) | #DIV/0! |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 417,667,110.79 | (417,667,110.79) | #DIV/0! |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 374.00 | 361.00 | 13.00 | 96.52 |
| 620001 | Удирдах ажилтан | 02.00 | 02.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 301.00 | 293.00 | 8.00 | 97.34 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 71.00 | 66.00 | 5.00 | 92.96 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | | 173,041.00 | (173,041.00) | #DIV/0! |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | 12,828.00 | (12,828.00) | #DIV/0! |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо | | 160,213.00 | (160,213.00) | #DIV/0! |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **374.00** | **361.00** | 13.00 | 96.52 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 303.00 | 295.00 | 8.00 | 97.36 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 71.00 | 66.00 | 5.00 | 92.96 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь "Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн, нотолгоонд суурилсан чанартай цогц, тусламж, үйлчилгээг үзүүлэх" зорилготой тус байгууллага нь 2024 онд 361 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2024.01.01-2024.07.05 хүртэлх хугацаанд даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч Ч.Жавзан, 2024.07.05-2024.11.25 хүртэлх хугацаанд тасгийн эрхлэгч, эмч Б.Чинбай, 2024.11.25-ны өдрөөс одоог хүртэл даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ганзул нар, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр нар зуржээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Эрүүл мэндийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, ХАБЭАТ хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/201 тушаалаар бүтэц орон тоонд өөрчлөлт орж 62 орон тоо нэмэгдсэн;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2023.06.16-ны өдөр баталж, 2024.01.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн;
- Баянхонгор аймгийн Засаг даргын 2024.04.09-ний өдрийн А/201 дугаар захирамжаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг баталсан байна.
- Сангийн сайдын 2024 оны 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн

засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан.

- Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлын төсвийг өмнөх жилүүдэд байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтээс санжүүлдэг байсныг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18-т заасны дагуу эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардлыг орон нутгаас санхүүжүүлдэг болсны дагуу аймгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг олгож эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/12 тоот тушаалаар “Дотоод хяналт, шалгалтын ажлын хэсэг-“ийг томилж, дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2024.07.06-ны өдөр дүгнэсэн байгаа тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй байгууллагаас бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,687.6 мянган төгрөгөөр буюу 100.2 хувиар нэмэгдэж оны эцэст 19,467,038.4 мянган төгрөг байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4,901.31 | 417,667.11 | 412,765.81 |
| Авлага | 1,484,128.00 | 1,875,387.41 | 391,259.40 |
| Бараа материал | 949,864.66 | 1,229,080.62 | 279,215.95 |
| Нөөцийн бараа | 571,864.90 | 571,864.90 | - |
| Үндсэн хөрөнгө | 24,927,935.06 | 25,846,831.31 | 918,896.24 |
| Хуримтлагдсан элэгдэл | (8,516,343.12) | (10,473,792.97) | (1,957,449.85) |
| **Нийт хөрөнгө** | **19,422,350.82** | **19,467,038.37** | **44,687.56** |
| Өр төлбөр | 1,757,062.35 | 1,596,673.11 | (160,389.24) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 17,665,288.47 | 17,870,365.26 | 205,076.80 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **19,422,350.82** | **19,467,038.37** | **44,687.56** |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны үзүүлэлтээс нилээ бүхий өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Оны эхэнд харилцах дансны үлдэгдэл 4,901.3 мянган төгрөг байсан ба оны эцэст 417,667.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан нь ЭМДС-аас 11 дүгээр сарын санхүүжилтэд 400,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2024.12.27-ны өдөр шилжүүлсэн боловч зарлагын гүйлгээ хийж амжаагүйтэй холбоотой байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс оны эхэнд 1,478,091.6 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагатай байсан, тайлант онд 16,084,118.6 мянган төгрөгийн үйлчилгээний төлбөрийг тус хэлтсээс нэхэмжилж, 16,480,229.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст 1,874,272.4 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагатай гарчээ.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 279,215.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,800,945.5 мянган төгрөг болсон нь тайлант онд Эрүүл мэндийн яамнаас 113,482.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын болон эм боох материал, аж ахуйн материал ирсэн, тайлант онд худалдан авсан эм боох материалыг зарцуулаагүй үлдэгдлээр байгаа зэрэгтэй холбоотой байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгө өмнөх оноос 918,896.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 25,846,831.3 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 65,134.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, иргэн Б.Батбаяр, Тээвэрчин хоршоо, Эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагаас 69,520.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандивласан, Эрүүл мэндийн яамнаас 815,122.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирсэнтэй холбоотой байна. Тайлант онд Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 17/67 дугаар тушаалаар 29,700.0 мянган төгрөгийн өртөг бүхий фургон автомашиныг акталж, дуудлага худалдаагаар борлуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 205,319.8 мянган төгрөгөөр нэмэгдэн Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,870,608.3 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант оны улсын төсвөөс олгох санхүүжилтийг 22,255,833.5 мянган төгрөгөөр төсөвлөснийг ЭМЯ-аас 7,477,284.9 мянган төгрөгөөр бууруулан анхны төсвийг 14,778,548.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Анхны баталсан төсвийн хуваарьт 5 дүгээр сард 98,400.0 мянга, 12 дугаар сард 3,577,502.9 мянган төгрөгөөр нэмж тодотгол хийж, нийт төсвийг 18,257,650.7 мянган төгрөгөөр баталжээ. Нийт баталсан санхүүжилтээс 16,365,943.7 мянган төгрөгийг ЭДМС-аас олгох санхүүжилтээр, 1,512,000.0 мянган төгрөгийг орон нутгаас олгох тогтмол зардлын санхүүжилтээр, 405,246.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталжээ.

Баянхонгор аймгийн ЭМДС-аас авахаар баталсан санхүүжилтээс 236,335.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу буюу 16,084,118.6 мянган төгрөгийг авч, орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг санхүүжүүлэхээр баталсан 1,512,000.0 мянган төгрөгийг бүрэн авчээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 405,246.2 мянган төгрөгийн оруулахаас гүйцэтгэлээр 367,754.2 мянган төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөө 37,492.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Баталсан санхүүжилтээс тайлант онд 11,236.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу буюу 994,017.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд нийт зардлын 96.2 хувийг буюу 955,724.4 мянган төгрөгийг зарцуулан оны эцэст зардлын хэмнэлтийн 38,292.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 71602 | Эмнэлэгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 14,268,035.10 | 14,262,172.02 | 5,863.08 | 100.0 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 29,146.20 | 28,600.38 | 545.82 | 98.1 |
| 83602 | Төсөвт байгууллагын өөрийн орлого/ туслах | 19,950.00 | 19,950.00 | - | 100.0 |
| 83603 | Нэмэлт-дээд шатны төсвөөс хувиарласан. | 2,428,519.40 | 2,057,387.40 | 371,132.00 | 84.7 |
| 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 1,512,000.00 | 1,202,704.16 | 309,295.84 | 79.5 |
| Дүн | | 18,257,650.70 | 17,570,813.96 | 686,836.74 | 96.2 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн хэлбэлзэл*

Байгууллагын даргын 2024 оны Б/49, Б/50 дугаар тушаалаар 2023 оны 04 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал, шилдэг албан хаагчдын шагналд олгох нийт 154,033.2 мянган төгрөгийг өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй атлаа 2024 оны батлагдсан төсвөөс зардлыг олгосон байна.

Тайлант онд тээврийн хэрэгсэлд олгосон сэлбэг хэрэгслийн бүртгэлийг автомашины хувийн хэрэгт хөтөлсөнтэй тулгахад 10-39 БНР, 24-29 БНА суудлын автомашинуудын хувийн хэрэгт 2024 онд олгосон сэлбэг хэрэгслийн дүнг 1,045.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн тул аудитын явцад зөрчлийг арилгуулсан ба цаашид бүртгэлийг сайжруулахыг зөвлөсөн.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/351 дүгээр тушаалаар байгууллагын удирдлагын ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн байгууллагын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн шийдвэрийг үндэслэн олгохоор заасны дагуу Удирдлагын зөвлөл үр дүнгийн урамшууллыг олгохыг баталгаажуулан ирүүлсэн байхад цалингийн нягтлан бодогч байгууллагын даргын тушаалын хавсралтад байгууллагын даргын олгох хувийг оруулж байгаад цаашид анхаарч ажиллахыг зөвлөв.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг 57 багцаар, хоол, хүнсний материал нийлүүлэх тендерийг 6 багцаар, шатах тослох материал, цэвэрлэгээ, аж ахуйн материал авах тендерүүдийг хуулийн дагуу зохион байгуулжээ.

Зохион байгуулсан тендерүүдээс БХАНЭ/20240102015 дугаартай “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер” шалгаруулалтын 29 дүгээр багцад “Чодбацо” ХХК шалгарсан, тус тендерт оролцсон “Био мед трейд” ХХК-аас гомдлыг Сангийн яаманд гаргасныг тус яам хянан гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн байна. Тус тендерийг дахин сонгон шалгаруулалт явуулан, Био мед трейд” ХХК-ийг сонгон шалгаруулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх тухай 28 дугаар албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан төсвийн 14,288,035.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 142,880.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 85,728.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг шинэчлэн тогтоогоогүй.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 675,780.7 мянган төгрөгийн 5 орлого, 388,426.4 мянган төгрөгийн 21 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, тус мэдээллүүдийг бүрэн байршуулсан боловч мэдээлэл харагдахгүй байгаа талаар албан бичгийг нотлох баримтын хамт ирүүлсэн тул энэ талаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтын мэргэжилтэнд мэдэгдсэн болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, "Хязгаарлалттай" дүгнэлт өгч, аудитаар илэрсэн 4 зөрчилд зөвлөмж өгснийг шалгагдагч байгууллага бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 4 | 204,693.9 | 4 | 204,693.9 | 100 |
| **Нийт дүн** | 4 | 204,693.9 | 4 | 204,693.9 | 100 |

*Эх сурвалж: ТАГ-ын санхүүгийн тайлангийн FAS систем*

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд аудит хийхэд хугацаа богино оногдож байгаагаас аудитаар зарим асуудлыг тодруулж, дараагийн аудитад дараах асуудлуудад анхаарах нь зүйтэй гэж аудитор үзэж байна. Үүнд:

- ЭМЯ-аас хуваарилагдаж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл хугацаа дуусах дөхсөн байхад нийлүүлж байгаа, өмнөх эмийн нөөц их байгаагаас ашиглаж чадахгүй зэргээс шалтгаалан эмийн хугацаа дуусаж байгаад анхаарах;
- Өөрийн орлогын төлөвлөгөө биелүүлэх;
- Бусад байгууллага, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээ байгуулж, гэрээний дагуу төлбөрийг төлж байгааг тодруулан шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,427.0 мянган төгрөгийн 4 алдаа[1] илэрснийг аудитын явцад дараахь байдлаар санхүүгийн тайланд залруулсан.Үүнд:

1. Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж тус байгууллагад нийлүүлсэн үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 1,181.1 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн;
2. "Баянхонгор Эм хангамж" ХХК-д төлөх өглөгийг санхүүгийн тайланд 243.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
3. Байгууллагын тооцооны нягтлан бодогч албан хаагчийн даатгуулагчийн төрлийг буруу мэдээлснээс нийгмийн даатгалын зардалд 283.3 мянган төгрөгийг илүү төлсөн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй;
4. Үндсэн хөрөнгөд 2024 онд бүртгэсэн 3,719.6 мянган төгрөгийн 5 хөрөнгийн ашиглах жилийг хасах 1 жил гэж оруулснаар тус хөрөнгүүдэд 2024 онд ногдох хуримтлагдсан элэгдэл бодогдоогүй байна.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө,

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

хөрөнгө оруулалт, авлага" 14.4.3 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх өр төлбөр", 14.4.6 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх зардал", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2024 оны А/229 дүгээр тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам "10 дугаар бүлэг Үндсэн хөрөнгө" зэргийг зөрчсөн байна.

Аудитаар нийт 3,884,690.0 мянган төгрөгийн 9 зөрчил[2] илэрснээс, 632.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 620,000.7 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,264,057.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн 3,884,690.0 мянган төгрөгийн зөрчлөөс 3,835,921.9 мянган төгрөгийг материаллаг бусаар тооцсон ба материаллаг алдаагаар тооцсон зөрчлийн дүн 48,768.1 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

1. Байгууллагын даргын 2024.01.23-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагчид 12 дугаар сард 572.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй албан хаагчид олгосон үр дүнгийн урамшууллаас суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хасан, 455.6 мянган төгрөгийг байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын цалингийн нягтлан бодогч ээлжийн амралттай албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн кодыг буруу мэдээлснээс төсвөөс 176.7 мянган төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь "Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

1. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын сангийн харилцах данс арилжааны банкинд байршсан, оны эцэст 342.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2024.12.25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3 дахь "Ахмадын

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сангийн хөрөнгө нь тухайн байгууллагын төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг байна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын сангийн дансыг Төрийн сан банкинд байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг 2024 оны 1, 3 дугаар сард 39,780.1 мянган төгрөгийн хугацаа дууссан, 2,012.8 мянган төгрөгийн хагарч гэмтсэн эм тариа байхад устгал хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, 72 дугаар зүйлийн 4-т “Тооллогын комисс дараахь үүрэгтэй: эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа дууссан, хагарч гэмтсэн эм, эмнэлгийн хэрэгслийг холбогдох эрх бүхий шийдвэрийн дагуу тухай бүрд акталж, устгалын актыг санхүүгийн баримтад хавсаргаж байх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга мэс заслын вакум хагалгааны хэсэг засврын гэрээг "Цолмон сүндэр" ХХК-тай 2022.11.14-ний өдөр гэрээ байгуулж, тус ажлыг 763,128.8 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр заасан бөгөөд аймгийн Нэгдсэн эмнэлгээс 571,864.9 мянган төгрөгийг олгож, санхүүгийн тайланд барааны нөөц дансанд бүртгэсэн боловч 2025.02.25-ны байдлаар ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Цолмон сүндэр" ХХК-аас 2025.02.21-ний өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт ирүүлсэн хүсэлтийн дагуу тус ажлыг 2025.04.01-ний дотор дуусгах, дуусгаагүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлж, төрд учирсан хохирлыг нэхэмжлэх албан шаардлагыг хүргүүлэв.

4. Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүнг тушаалын дагуу Удирдах зөвлөлд танилцуулаагүй, ерөнхий нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, комиссын гишүүд гарын үсгээр тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “ Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4-т “Тооллогын комисс дараахь үүрэгтэй: комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг албажуулан, тооцоо бодсон актаар албажуулан, тушаалын дагуу Удирдлагын зөвлөлд танилцуулж, байгууллагын архивд шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

**5.3. Зөвлөмж**

1. Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 569 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй бөгөөд хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэснийг хэрэгжүүлж ажиллах

2. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйлдвэрлэж, эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүчилтөрөгчийн журнал, бүртгэл хангалтгүйгээс ашигласан хүчилтөрөгчийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэж буй хүчилтөрөгчийн нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

3. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн зарим албан хаагчид үндсэн ажлын албан тушаалын дагуу хийж байгаа ажлын нэмэгдэлд хавсарган гүйцэтгэсний 10 хувийг авч байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт болон тус тогтоолын 2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэн ажиллах

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| "Баянхонгор Эм хангамж" ХХК-д төлөх өглөгийг санхүүгийн тайланд 243.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 243.0 | 1 | 243.0 | | | 1 | 243.0 | | |
| Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж тус байгууллагад нийлүүлсэн үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 1,181.1 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. | 1 | 1,181.1 | | | 1 | 1,181.1 | 1 | 1,181.1 | | |
| Тайлант онд үндсэн хөрөнгөд бүртгэсэн 3,719.6 мянган төгрөгийн 5 хөрөнгийн ашиглах жилийг хасах 1 жил гэж оруулснаар тус хөрөнгүүдэд 2024 онд ногдох хуримтлагдсан элэгдэл бодогдоогүй байна. | 1 | 3,719.6 | | | 1 | 3,719.6 | 1 | 3,719.6 | | |
| Байгууллагын тооцооны нягтлан бодогч албан хаагчийн даатгуулагчийн төрлийг буруу мэдээлснээс нийгмийн даатгалын зардалд 283.3 мянган төгрөгийг илүү төлсөн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 1 | 283.3 | 1 | 283.3 | | | 1 | 283.3 | | |
| ДҮН | 4 | 5,427.0 | 2 | 526.3 | 2 | 4,900.7 | 4 | 5,427.0 | 0 | 0 |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын даргын 2024. 01.23-ны өдрийн Б/42 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 1 албан хаагчид 12 дугаар сард 572.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. | 1 | 455.6 | 1 | 455.6 | | | | |
| Байгууллагын цалингийн нягтлан бодогч ээлжийн амралттай албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн кодыг буруу мэдээлснээс төсвөөс 176.7 мянган төгрөгийг илүү төлсөн байна. | 1 | 176.7 | 1 | 176.7 | | | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахмадын сангийн харилцах данс арилжааны банкинд байршсан, оны эцэст 342.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. | 1 | 342.8 | | | 1 | 342.8 | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг 2024 оны 1, 3 дугаар сард 39,780.1 мянган төгрөгийн эмийн хугацаа дууссан, 2,012.8 мянган төгрөгийн эм тариа хагарч гэмтсэн байхад зарлагадаагүй байна. | 1 | 47,793.0 | | | 1 | 47,793.0 | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга мэс заслын вакум хагалгааны хэсэг засварын гэрээг "Цолмон сүндэр" ХХК-тай 2022.11.14-ний өдөр гэрээ байгуулж, тус ажлыг 763,128.8 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр заасан бөгөөд аймгийн Нэгдсэн эмнэлгээс 571,864.9 мянган төгрөгийг олгож, санхүүгийн тайланд барааны нөөц дансанд бүртгэсэн боловч 2025.02.25-ны байдлаар ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгээгүй байна. | 1 | 571,864.9 | | | 1 | 571,864.9 | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 569 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй бөгөөд хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна. | 1 | 3,264,057.0 | | | | | 1 | 3,264,057.0 |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйлдвэрлэж, эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа хүчилтөрөгчийн журнал, бүртгэл хангалтгүйгээс ашигласан хүчилтөрөгчийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Эд хөрөнгийн тооллогын дүнг тушаалын дагуу Удирдах зөвлөлд танилцуулаагүй, ерөнхий нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, комиссын гишүүд гарын үсгээр тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн зарим албан хаагчид үндсэн ажлын албан тушаалын дагуу хийж байгаа ажлын нэмэгдэлд хавсарган гүйцэтгэсний 10 хувийг авч байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 9 | 3,884,690.0 | 2 | 632.3 | 4 | 620,000.7 | 3 | 3,264,057.0 |

---oOo---